

2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компанийн товч танилцуулга

“Хөвсгөл-Алтандуулга”ХК нь 1943 онд Хөвсгөл аймгийн Тариалан суман дахь САА-н суурин дээр байгуулагдаж, үр тарианы томоохон аж ахуйн нэгж болон өргөжиж, бүс нутгийн хүнсний хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байсан түүхтэй. 1992 онд өмч хувьчлалын хуулиар төрийн өмч давамгайлсан 6 компани болон хуваагдсан. Зах зээлийн шилжилтийн үед Одос, Хушт, Баянхошуу, Алтан эмээлт компаниуд бие даан ажиллаж чадахгүй болсноор 1995 оноос “Хөвсгөл-Алтандуулга”ХК -тай нэгдсэн юм.

1996 онд төрийн өмчийн мэдэлд байсан тус компанийн нийт хувьцааны 70,7 хувийг “Тэстрейд” ХХК дуудлага худалдаагаар хувьчилж авсан. Одоо Хөвсгөл Алтандуулга ХК нь нийт 113286 ш хувьцааг 256 хувьцаа эзэмшигч эзэмшин Хөрөнгийн биржийн 3 ангилалын самбар дээр бүртгэгдсэн байна.

“Хөвсгөл-Алтандуулга”ХК үр тариа, улаан буудайн гурил, тэжээл, мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт 68 үндсэн ажиллагсадтай, 7150 гаруй га эргэлтийн талбайд үр тарианы үйлдвэрлэл эрхэлж, John Deere, New Holland, Flexi Coli, Borgault гэх мэт дэлхийн нэртэй үйлдвэрлэгч нарын трактор комбайн, үрлэгч зэрэг тоног төхөөрөмж, технологийн иж бүрэн шинэчлэл хийн ажиллаж байна. Ийнхүү технологийн шинэчлэл хийснээр газар тариалангийн үйлдвэрлэлийн хувьд хөрсний үржил шимийг хамгаалах, хөрсийг элэгдлээс хамгаалах, байгальд ээлтэй, бага зардалтай өндөр бүтээмжтэй болсон давуу талтай.

2012 онд 4000 тн үр тариа хадгалах хатаалгатай иж бүрэн механикжсан байгууламжийг, хоногт 100тн буудай тээрэмдэх хүчин чадалтай гурилын үйлдвэрийн хамт барьж ашиглалтанд орууллаа. Уг үйлдвэр ашиглалтанд орсноор олон нэр төрлийн буудайн чанартай гурил үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэж байна. Компани бүтээгдхүүнээ Хөвсгөл аймгийн бүх сумууд болон хил залгаа аймаг, сумдуудад бүрэн түгээж, мөн Улаанбаатарын хэрэглэгчдэд таниулж эхлээд байна.

Манай компани 2011-2017 онд нийт 5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтыг өөрийн болон банкны зээлийн эх үүсвэрээр хийж, техник тоног төхөөрөмжийн бүрэн шинэчлэл хийн, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, борлуулалтын хэмжээг өсгөн, зах зээлийг тэлэх бодлого хэрэгжүүлж ажиллалаа. Шинэ технологи нэвтрүүлсний үр дүнд үр тарианы үйлдвэрлэлийн нэг га-гаас авах ургацын хэмжээ өсч, улсын дундажийн хэмжээнд, өндөр чанартай үр тариа хураан авч, чанартай харьцангуй хямд бүтээгдхүүнээр хэрэглэгчдээ хангаснаар бүтээгдхүүний нэр хүнд тогтож, байнгын тогтвортой хэрэглэгчидтэй болж чадлаа. Улаанбаатар хотод борлуулалтын суваг нээж, Номин, Сансар, Хангалуун трейд борлуулалтын сүлжээгээр гурилаа нийлүүлж байсан ба өнөөдөр Оргил худалдааны төвөөр дамжуулан, мөн хүргэлтээр хэрэглэгчдэдээ хүргэж эхлээд байна. Алс холын Хөвсгөлийн бүс нутгаас төвлөрсөн зах зээлд гурил нийлүүлж, танигдаж эхэлж байгаагаараа онцлогтой юм.

Бүсийн хэмжээнд үр тариа эрхэлдэг бусад аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, тэдний тарьж ургуулсан бүтээгдэхүүнийг худалдан авч хамтран ажилладаг сайн жишиг тогтож байгаа нь бидний хийсэн хөрөнгө оруулалтын томоохон өгөөжийн нэг юм. Техник технологи шинэчлэснээр нэгж бүтээгдэхүүнд ноогдох зардал буурч, ажиллах хүчний тоо багасах боломж буй болж байгаа ч бид үйлдвэрлэлээ өргөжсний хирээр ажлын байр нэмэгдүүллээ.

2018 онд экспортод чиглэсэн бүтээгдхүүн хөгжүүлэлтийг хийж борлуулалтыг нэмэгдүүлэн санхүүгийн бие даасан байдлыг сайжруулж, мэргэжилтэй боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлж ажиллах зорилготой ажиллана.

Газар тариалангийн үйл ажиллагааны талаар

Газар тариалангийн талаар 2017 онд тавьсан зорилтууд:

- ✓ Талбайн хөрсний үржил шимийг одоо байгаагаас дордуулахгүй байхад анхааран ажиллах/ бордоо хэрэглэх, сүрлэн хучлагыг технологийн дагуу хийх хашаажуулах/
- ✓ Техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарах. Одоо байгаагаас солих,
- ✓ Мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдах/Үйлдвэрлэлийн сургалтаар/
- ✓ Тариалалтын технологийн ажлын гүйцэтгэл бүрийг чанартай үр дүнтэй хийж гүйцэтгэхэд анхааран ажиллаж, хаягдал, гологдолгүй ажиллах

2017 онд 3924 га талбайд улаан буудай, 300 га-д тосны ургамал, 29 га-д арвай, 21 га-д овьёос тариалав. Гэвч сүүлийн 40 жил болоогүй их халалт хуурайшилт болж, эхний бороо 7 сард орсноос ургамлын ургалтанд нөлөөлж нийт тариалсан талбайнхаа 1606 га-д 100% ургац алдаж, 2318 га-аас 4.5 цн буудай хурааж авснаас үрэнд 220 тн, таваарт 640, тэжээлийн буудай 160,0 хог хаягдалд 20,1 тн тус тус шилжүүллээ. 300 га тосны ургамлаас 7500 боодол тэжээл боож мал аж ахуйд шилжүүлэн, арвай, овьёос га-аас 0,6-1,4 цн ургац авлаа.

ОХУ- улсад үйлдвэрлэсэн гуматын бордоог тариалалтанд үрэнд шингээж, ургалтын явцад ургамал хамгааллын бодистой хамт хэрэглэсэн.

Уринш боловсруулалтыг тэг болон цомхотгосон, мөн механик уриншийг хийлээ. Механик уринш 1336 га-д, тэг уринш 384 га, цомхотгосон уринш 1157 га-д тус тус хийсэн ба уриншийн гербицидийг ТЭДС-аас нийлүүлсэн бодисыг ашиглаж хийлээ.

Ургамал хамгааллын ажлыг бороо хүлээж 7 сар гаргаж хийсэн ба Гацуурт ХХК-ийн Балерина, Ластик топ, Галион гербицидийг ашиглан нийт 3059 га-д хийв.

Намар бороо оройтож, буудайн болцонд нөлөөлж ургац алдсан зарим талбай намар сэргэж ногоон масс түрсэн тул малчдад хадлангийн талбайд хувиарлан нийт буудай тарьсан 600 га талбайгаас малчид хадлан бэлтгэж авсан.




Рапс тарьсан талбайгаас түүвэрлэн хурааж 4 тн орчим рапс хураан авсан боловч борлуулалт хийгээгүй. Харин ногоон массыг малын тэжээлд боож авлаа.

2 хүнийг үйлдвэрлэл дээрхи сургалтанд хамруулж операторчнаар ажиллах дадлага хийлгэн ажиллуулж эхэлсэн.

Тариалалт, ургамал хамгаалал, хураалтын ажлыг тавьсан зорилтын дагуу хийж гүйцэтгэсэн боловч байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн үр дүнг тооцох боломжгүй болсон.

Уриншийн чанар сайн болсон боловч бүс нутгийн бэлчээрийн гарц муу, малын тоо толгой нэмэгдсэнээс тариалангийн талбайд бэлчих малын тоо улам нэмэгдэж, мөн цасан хучлага байхгүй байгаагаас талбай сүйтгэгдэх нөхцөл давхар бүрдсэн байгаа нь ажиллагдаж байна. Иймд цаашид талбайг малын хөлөөс хамгаалан хамгаалалтын хашаа байгуулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Мөн хөрсний үржил шимийг алдуулахгүй хамгаалах сайжруулахад шаардлага байнга тулгарч байгаа тул цулгүй уринш хийхийг бүрэн зогсоож талбайд сэлгээний ургамлыг тарьж өнжүүлэх, эсвэл ургамлын үлдэцээр талбайг бүрэх технологийн ажиллагааг хийх хэрэгтэй байна.



Гурил тэжээлийн үйлдвэрлэлийн талаар

2017 онд нийт 2295.2 тн буудай тээрэмдэж, 1841.8 тн гурил, 449.3 тн хивэг үйлдвэрлэсэн байна.



Гурилын үйлдвэрт хөрөнгө оруулалт хийж цаасан савлагаатай 2 кг-ийн гурил савлах шинэ төхөөрөмж БНХАУ-аас импортлон суурилуулан ашиглалтанд оруулсан. Ажиллагсдын амрах, хооллох байр шинээр нэмж барихаар төлөвлөсөн боловч санхүүгийн байдлаас шалтгаалан хойшлуулаа.

Үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг газар тариалангийн үйлдвэрлэлээс нийлүүлэх буудай болон гаднаас худалдаж авахаар төлөвлөж байсан боловч ургац алдалтаас шалтгаалан түүхий эдийн олдоц хомс үнэ өндөр байснаас төлөвлөсөн хэмжээнд нөөцлөх боломжгүйд хүрлээ. Улаанбуудайг ОХУ-аас импортлох боломж үүссэн боловч ХХААХҮЯ-аас улаанбуудай импортлох квот ондоо багтаж олгогдоогүй болно.

Борлуулалтын хувьд үйлдвэрлэсэн бүтээгдхүүн 100% борлогдож, эрэлт ихтэй байлаа.

Борлуулалтын сувгийг нэмэх, идэвхижүүлэх, хэмжээг нэмэх, борлуулалтын системийг тогтоох зорилгоор Тэс трейд ХХК-аас Маркетинг борлуулалтын багийг хөлслөн ажиллуулахаар төлөвлөж, Улаанбаатар хотод социал маркетингийн хэлбэрээр бүтээгдхүүнээ сурталчилж, хүргэлтийн үйлчилгээ хийж эхлээд байна.

Санхүү, хөрөнгийн удирдлага

Компанийн ерөнхий удирдлагын чадавхийг дээшлүүлэх цогц бодлогын томоохон бүрэлдхүүн хэсэг нь санхүү, хөрөнгийн удирдлагын чиглэл юм. 2014 оноос хөндлөнгийн бие даасан мэргэжлийн байгууллагуудаар үнэлгээ, шинжилгээ хийлгэх, санхүүгийн удирдлагыг мэргэжлийн түвшинд хүргэж, сайжруулах төлөвлөгөө боловсруулан ажиллаа. Энэ ажлыг санхүү, хөрөнгө оруулалтын зөвлөх компани болох “Ваалюк” ХХК-тай урт хугацааны гэрээ байгуулан 3 дахь жилдээ ажиллаж байна. Мөн санхүү бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг мэргэшүүлэн, олон улсын стандарт жишигт нийцүүлэх үүднээс олон улсад нэр хүнд бүхий БДО аудитын компанитай 2 жил, Од бүртгэл аудиттай 1 жил хамтран ажиллалаа.

2015, 2016, 2017 онуудад компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийг дүгнэж, босго тогтоон аажмаар системтэй сайжруулан, санхүүгийн удирдлагын болон дотоод хяналтын арга барил, дотоод системүүдийг бүрдүүлэн бэхжүүлэхэд анхаарч ажиллав. Үүнд:

1. Санхүү нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн цогц системийг компанийн үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийцүүлэн боловсрууллаа. Үйл ажиллагааны төрөл, чиглэл, газар хэлтэс нэгж бүрээр ангилан санхүү бүртгэлийн ажлыг зохион байгуулж, удирдлагын цаг үеийн чухал мэдээллийг ERP Veritech системээр бэлтгэн гаргадаг боллоо.

2. Санхүүгийн мөнгөн урсгалын төлөвлөлт, санхүүгийн нөөцийн ашиглалтыг сайжруулан төлөвлөлт, тайлан мэдээний загвар гарган, удирдлагад нэвтрүүллээ.
3. Борлуулалт, бараа материалын хөдөлгөөний тайланг бүх нэгжүүдээр өдрөөр нэгтгэн, тайлан мэдээ бэлтгэдэг болов.
4. Нягтлан бодох бүртгэлийн аккрузал системд шилжин, дансны төлөвлөгөө, код боловсруулан, системлэж, зохистой удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг бүрэн нэвтрүүллээ.
5. Удирдлагад зориулсан цаг үеийн оновчтой, зөв шийдвэр гаргалтыг хангах, санхүүгийн удирдлагын тайлан мэдээний нэгдсэн систем боловсруулан нэвтрүүлж дууслаа.
6. Компанийн хөрөнгө санхүү нийт үйл ажиллагааны зохистой удирдлага, үр ашгийг дээшлүүлэхэд онцгой анхаарч, хөрөнгийн ашиглалт, үр өгөөж сайжирлаа.
7. Санхүү бүртгэлийн ERP Веритех системийн цалин хөлс, нягтлан бодох бүртгэлийн модулиудыг нэвтрүүлэх төгсгөлийн шатанд явж байна. Энэхүү системийг санхүү бүртгэлийн дотоод системтэй уялдуулж нэвтрүүлснээр өртөг зардлаа тооцох дэвшилтэт аргачлалтай болж, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг бодитоор тооцох, бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийг оновчтой бэлтгэдэг болсноор компанийн удирдлагын бүх түвшинд оновчтой шийдвэр гаргах боломжийг бүрдүүлж байна.
8. Санхүүгийн албаны бүтцийг буй болгон, санхүүгийн ажилтнуудыг ур чадварыг дээшлүүлэх, ажлын байрны тодорхойлолт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, шинэчиллээ.
9. Санхүү хөрөнгийн эх үүсвэрийн ужигарсан дутагдал, санхүүгийн зээлийн хүүний зардлын дарамтаас чөлөөлөх санхүүгийн тооцооллыг хийж, Хаанбанкны зээлийн нөхцөл, бүтцийг өөрчлөн, найдвартай эх үүсвэрээр хангуулах үүднээс ХАА-н хөнгөлттэй зээлийн хөтөлбөрт хамруулан хамтарч ажиллаа. Үүний үр дүнд зээлийн хүүгийн зардлыг бууруулж, эргэлтийн хөрөнгийн дутагдлыг багасгав.
10. Компани үйл ажиллагааны чадавхиа хүчтэй сайжруулж, цалин хөлс ажиллагсдын нийгмийн хангамжийг бүрэн анхаарч, дотоод чадавхиа бэхжүүлэх томоохон арга хэмжээнүүдийг авч ажиллаа.
11. Санхүү бүртгэлийн чиглэлээр хөндлөнгийн бие даасан, мэргэшсэн нийт 5 зөвлөхүүд, мэргэшсэн 5 компани хамтран ажиллаж, санхүү бүртгэл дотоод хяналт, УМС-ийн чиглэлээр дотоод системийн сайжруулалт хийж, байнгын зөвлөхөөр ажилласан нь компанийн цаашдын өсөлтөд хөгжилтөд чухал ач холбогдолтой боллоо.

Мөн Ваалюк ХХК-тай байгуулсан гэрээний хүрээнд санхүү бүртгэлийн иж бүрэн систем нэвтрүүлэх, санхүүгийн программ хангамж суурилуулах, удирдлагын тайлангийн систем боловсруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажил хийгдэж дууссанаар компани санхүүгийн удирдлага, хяналтын дотоод системээ бүрдүүллээ.

2017 онд арилжааны банкнаас авсан зээлийн хүүд 409 534 мян төгрөг төлсөн байна.

Компани ХААН банкинд хүсэлт гарган 1.2 тэрбум төг-ийн зээлийн шугамыг дахин 2 жилээр сунгуулж, хүүг 2.4 пунктээр бууруулж шийдвэрлэсэн. Мөн Хөгжлийн банкнаас санхүүжилттэй 1.25 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийн дүнгээс 2017 онд 371.3 сая төг-ийн эргэн төлөлт хийгдэж 878.7 сая төг-ийн үлдэгдэлтэй байна. ХААН банкны урт хугацаат зээл (263.6 сая төг)-ээс 63.4 сая төг-ийн эргэн төлөлт хийгдэж оны эцсийн байдлаар 76.0 сая төг-ийн үлдэгдэлтэй байна.

Эрсдлийн удирдлага

Эрсдэл

- Тариалангийн бүсэд ган, мөндөр, үер гэх мэт цаг уурын таагүй байдал бий болж төлөвлөсөн ургац буурах, үүнээс улбаалж буудайны өртөг нэмэгдэж нөөц багассанаар 2016-2017 оны гурилын үйлдвэрлэлд нөлөөлөх
- Дэлхийн Хүнс, ХАА-н байгууллагаас ирэх 2-3 жилд дараалан ган болох хамгийн өндөр магадлалтай хэмээн анхааруулан 10 орны тоонд Монгол улс багтсан байна.

Арга хэмжээ

Бид жил бүр байгалийн эрсдлийг бууруулахад анхааран ажиллахыг чармайдаг бөгөөд өнгөрсөн жилийн хувьд ган болох магадлалыг ганд тэсвэртэй үрийг түлхүү ашиглах, ган тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлдэг гуматын бордоог ашигласан. Үүний үрээр хүчтэй ган болсон хэдий ч бага ч гэсэн ургац хурааж чадсан гэж үзэж байна.

Эрсдэл

- Засгийн газраас буудайны ургацад олгох урамшууллын хэмжээ буурч байгаа
- Гурилын үйлдвэрлэлийн салбарт өрсөлдөөн хүчтэй болж байгаагаас зах зээлд эзлэх жингээ алдах эсвэл үнэ буурснаас нийт ашгийн маржин буурч болзошгүй

Арга хэмжээ

Энэ эрсдлийн хүчин зүйл манайд гангаас илүү нөлөөлж байгаа ба энэхүү нөлөөг багасгахад үйлдвэрлэл тогтвортой ажиллаж бүтээгдхүүнээ зах зээлд байнга нийлүүлж үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, борлуулалт маркетингийн цогц бодлого журмыг боловсруулан хэрэгжүүлэх арга замаар эрсдлийг бууруулахаар төлөвлөсөн байсан ба ургац алдсан шалтгаанаар хэрэгжихэд хүндрэл гарсан. Бид 2018 оны төлөвлөлтөнд энэхүү ажлуудыг бүрэн тусгаж хийхээр төлөвлөсөн болно.

Эрсдэл

- Газар тариалангаас авах буудайн хэмжээ гурилын үйлдвэрлэлийн өсөлтийг цаашид гүйцэхгүй тул импортын буудайнаас хамаарах байдал улам бүр нэмэгдэх, нөгөө талдаа мөнгөн хөрөнгийн дутагдалтай тул банкны зээлээс хамааралтай байдал үргэлжлэх

Арга хэмжээ

2017 оны хувьд түүхий эдийн нөөц бүрдүүлэх ажилд хүндрэлтэй байлаа. Монгол улс нийт буудайн хэрэгцээний 40% хангахуйц ургац авснаас шалтгаалан ОХУ-аас 225,0 мянган тн хүнсний буудай оруулж ирэх квот олгохоор болж байгаа ба манай компани квотоос 10 мян. тн авах хүсэлтээ гаргаад байна. Квотын буудай худалдан авах санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байгаа ба үүнийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагааны талаарх зарим статистик үзүүлэлттэй Хавсралт 1-ээс, санхүүгийн тайланг МХБ-ийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

Хүснэгт 1. Компанийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Тариалангийн эргэлтийн талбай /га/	6 175	6 175	7 150	7 150	7 150
Үүнээс: -тарьсан	3 603	2 888	4 948	4 319	4 274
Ураншилсан	2 572	3 287	2 202	2 831	3 177
Таримлын төрөл	Улаанбуудай, овъёос, халтар арвай	Улаанбуудай, овъёос, рапс, халтар арвай	Улаанбуудай, овъёос, рапс, халтар арвай	Улаанбуудай, овъёос, рапс, халтар арвай	Улаанбуудай, овъёос, рапс, халтар арвай
Хураан авсан ургац /тн/	4 808,9	3 617,8	2 406,6	5 869,0	1 045,0
Нэг га-ийн ургац /цн/	13,3	13,4	4,9	13,8	4,4
Үйлдвэрлэсэн гурил /тн/	3 808,3	3 293,5	3 757,1	3 215,2	1 841,8
Тэжээл /тн/	650,0	665,0	710,0	642,3	375,0
Борлуулалт /мян. төгрөг/	3 130 254,2	3 433 572,8	3 680 404,0	3 032 439,9	2 461 114,9
Үүнээс: татварт /мян.төг/	42 693,4	68 501,7	72 048,1	31 257,4	22 637,6
НДШ-д /мян.төг/	69 739,4	71 719,5	63 760,8	56 830,0	83 700,0
Ашиг /мян.төг/	209 643,4	652 888,6	-323 869,2	71 344,3	36 843 ,0
Ажлын байрны тоо	78	80	75	75	73